



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/09/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: В.Жавзмаа Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 30

танай _____ -ны № _____ -т

БАЯН-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Э.ГЭРЭЛМАА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өндөр сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баян-Өндөр сумын ИТХ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

2021 онд төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлсэн Засгийн газрын тогтоолыг мөрдөхгүйгээр 2,669.9 мянган төгрөгийн нормын хувцас, тавилга худалдан авсан, тайлант хугацаанд худалдан авсан 8,516.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулалтын нормоор хянаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангуулахгүйгээр зарцуулсан, мөнгөн кассын тайлан хөтлөөгүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг

удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”; Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын 1.4 дэх заалт “... албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал “Жишиг норм батлах тухай”-ын хавсралт 1 “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, хавсралт 2 “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд” гэж заасантай нийцэхгүй, аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,832,230.40</u>	<u>4,769,091.39</u>
33	АВЛАГА	-	224,600.99
335	Бусад авлага	-	224,600.99
3351	Байгууллагаас авах авлага	-	74,600.99
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	150,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,832,230.40	4,544,490.40
351	Түүхий эд материал	3,381,230.40	3,980,290.40
35110	Тусгай зориулалттай материал	3,381,230.40	3,980,290.40
354	Хангамжийн материал	451,000.00	564,200.00
35410	Бичиг хэргийн материал	403,000.00	446,100.00
35420	Аж ахуйн материал	48,000.00	76,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	42,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>77,012,896.11</u>	<u>82,830,527.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	77,012,896.11	82,830,527.01
392	Биет хөрөнгө	74,760,396.26	80,890,527.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,792,946.50	3,792,946.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(237,059.10)	(426,706.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	62,645,000.00	63,650,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,756,250.00)	(28,606,874.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,814,450.00	87,882,880.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,910,132.92)	(52,786,322.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,910,440.00	26,058,340.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,498,998.22)	(18,673,735.44)
393	Биет бус хөрөнгө	2,252,499.85	1,939,999.81
39301	Программ хангамж	1,930,000.00	1,930,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(637,500.15)	(950,000.19)
39303	Бусад биет бус хөрөнгө	960,000.00	960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>80,845,126.51</u>	<u>87,599,618.40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>17,350.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	17,350.00
413	Өглөг	-	17,350.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	17,350.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>80,845,126.51</u>	<u>87,582,268.40</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	80,845,126.51	87,582,268.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,696,125.67	16,696,125.67
51101	Өмч: - төрийн	16,696,125.67	16,696,125.67
512	Хуримтлагдсан үр дүн	61,865,120.44	68,602,262.33
51210	Өмнөх үеийн үр дүн	61,865,120.44	61,865,120.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,737,141.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,283,880.40	2,283,880.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>80,845,126.51</u>	<u>87,599,618.40</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	229,498,300.00	290,555,730.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	53,876,930.10
120	Нийтлэг татварын бус орлого	-	53,876,930.10
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		53,660,930.10
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		216,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,498,300.00	236,678,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	12,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	226,498,300.00	224,678,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	226,498,300.00	224,678,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	234,898,721.67	256,117,963.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	234,898,721.67	256,117,963.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,093,379.76	242,391,278.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125,553,465.43	133,563,348.00
210101	Үндсэн цалин	125,553,465.43	133,563,348.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,097,822.66	16,590,862.35
210201	Тэтгэврийн даатгал	10,631,743.54	11,057,150.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,250,793.35	1,569,585.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,000,629.78	1,173,505.80
210204	Ажилгүйдлийн даатгал	153,224.47	171,103.69
210205	Эрүүл мэндийн даатгал	2,061,431.52	2,619,517.20
2104	Хангамж, бараа материалын зардал	12,926,540.00	18,927,418.00
210401	Бичиг хэрэг	3,256,600.00	6,137,750.00
210402	Тээвэр, шатахуун	6,666,000.00	8,502,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,442,110.00	1,564,628.00
210404	Ном, хэвлэл	1,004,000.00	2,277,840.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	557,830.00	444,400.00
2105	Нормативт зардал	152,600.00	152,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	152,600.00	152,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,408,500.00	3,571,700.00
210604	Урсгал засвар	1,083,000.00	3,571,700.00
2107	Томилолт, зочны зардал	684,000.00	414,000.00
210702	Дотоод албан томилолт	684,000.00	414,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,391,330.00	6,045,110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,561,200.00	4,634,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,430.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,400.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,123,000.00	1,115,000.00

Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	41,300.00	34,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,839,621.67	63,126,840.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,326,900.00	36,441,266.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,800,000.00	4,025,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,712,721.67	22,660,574.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,805,341.91	13,726,684.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,694,100.00	9,691,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,316,000.00	9,691,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,111,241.91	4,034,784.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,111,241.91	3,034,784.52
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(5,400,421.67)</u>	<u>34,437,766.89</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	27,700,625.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	27,700,625.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(27,700,625.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(5,400,421.67)</u>	<u>6,737,141.89</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,696,125.67	2,283,880.40	67,265,542.11	86,245,548.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,696,125.67	2,283,880.40	67,265,542.11	86,245,548.18
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(5,400,421.67)	(5,400,421.67)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,696,125.67	2,283,880.40	61,865,120.44	80,845,126.51
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,696,125.67	2,283,880.40	61,865,120.44	80,845,126.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,696,125.67	2,283,880.40	61,865,120.44	80,845,126.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				

Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тайлант үеийн үр дүн			6,737,141.89	6,737,141.89
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,696,125.67	2,283,880.40	68,602,262.33	87,582,268.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>229,498,300.00</u>	<u>237,745,300.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,498,300.00	237,745,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	12,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	226,498,300.00	224,678,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	226,498,300.00	224,678,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	1,066,500.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1,066,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>228,248,300.00</u>	<u>235,227,400.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	228,248,300.00	235,227,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,466,958.09	219,776,115.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125,079,765.43	133,787,948.99
210101	Үндсэн цалин	73,736,618.43	78,554,876.99
210102	Нэмэгдэл	51,343,147.00	55,233,072.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,097,822.66	16,590,862.35
210201	Тэтгэврийн даатгал	10,631,743.54	11,866,039.69
210202	Тэтгэмжийн даатгал	1,250,793.35	1,315,345.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,000,629.78	1,052,276.44
210204	Ажилгүйдлийн даатгал	153,224.47	162,883.65
210205	Эрүүл мэндийн даатгал	2,061,431.52	2,194,317.40
2104	Хангамж, бараа материалын зардал	12,456,560.00	14,342,678.00
210401	Бичиг хэрэг	2,916,200.00	3,022,850.00
210402	Тээвэр, шатахуун	6,620,000.00	7,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,442,110.00	1,716,288.00
210404	Ном, хэвлэл	908,400.00	2,162,340.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	569,850.00	341,200.00
2105	Нормативт зардал	152,600.00	152,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	152,600.00	152,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,454,500.00	3,318,800.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	3,318,800.00
2107	Томилолт, зочны зардал	684,000.00	414,000.00
210702	Дотоод албан томилолт	684,000.00	414,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,391,330.00	6,660,110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,561,200.00	5,249,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	120,430.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,400.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,123,000.00	1,115,000.00
210807	Газрын төлбөр	41,300.00	34,100.00

Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,150,380.00	44,509,716.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,350,380.00	40,479,716.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,800,000.00	4,030,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,781,341.91	15,451,284.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,670,100.00	11,416,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	1,066,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,845,600.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,532,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,292,000.00	10,350,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,111,241.91	3,034,784.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,111,241.91	3,034,784.52
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,250,000.00</u>	<u>2,517,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,250,000.00	2,517,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,250,000.00	2,517,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,250,000.00	2,517,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,250,000.00	2,517,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,250,000.00)</u>	<u>(2,517,900.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	224,678,800.00	221,644,015.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,678,800.00	221,644,015.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	220,299,600.00	217,294,015.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,411,500.00	133,787,948.99
210101	Үндсэн цалин	79,178,400.00	78,554,876.99
210102	Нэмэгдэл	55,233,100.00	55,233,072.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,801,400.00	16,590,862.35
210201	Тэтгэврийн даатгал	11,425,000.00	11,866,039.69
210202	Тэтгэмжийн даатгал	1,344,100.00	1,315,345.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,075,300.00	1,052,276.44
210204	Ажилгүйдлийн даатгал	268,800.00	162,883.65
210205	Эрүүл мэндийн даатгал	2,688,200.00	2,194,317.40

Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	12,903,200.00	12,342,678.00
210401	Бичиг хэрэг	3,116,200.00	3,022,850.00
210402	Тээвэр, шатахуун	6,600,000.00	6,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,537,000.00	1,716,288.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	662,340.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	650,000.00	341,200.00
2105	Нормативт зардал	152,600.00	152,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	152,600.00	152,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,838,800.00	5,836,700.00
210602	Тавилга	2,100,000.00	2,097,900.00
210604	Урсгал засвар	3,738,800.00	3,738,800.00
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	414,000.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	414,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,768,300.00	6,160,110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,800,000.00	4,749,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,123,000.00	1,115,000.00
210807	Газрын төлбөр	41,300.00	34,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,723,800.00	42,009,716.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,623,800.00	39,979,716.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,100,000.00	2,030,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,379,200.00	4,350,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,379,200.00	4,350,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,379,200.00	4,350,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	226,172,800.00	221,644,015.48
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	226,172,800.00	221,644,015.48
132001	Орон нутгийн төсвөөс	226,172,800.00	221,644,015.48
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5.50	5.50
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.50	3.50
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5.50	5.50
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.50	3.50
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,700,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,700,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00
210404	Ном, хэвлэл	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өндөр сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өндөр сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Өндөр сумын ИТХ нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод хяналт, аудит хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өндөр сумын ИТХ 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 224,678.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,370.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,359.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Өндөр сумын ИТХ 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,754.5 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		224.6	224.6
Бараа материал	3,832.2	4,544.5	712.3
Үндсэн хөрөнгө	77,012.9	82,830.5	5,817.6
Нийт хөрөнгө	80,845.1	87,599.6	6,754.5
Өр төлбөр		17.4	17.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	80,845.1	87,582.2	6,737.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	80,845.1	87,599.6	6,754.4

Авлагын данс 224.6 мянган төгрөг болж нэмэгдсэн нь цалингийн зардлаас шалтгаалсан нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бусад зардлын тооцооноос шалтгаалсан байна.

Бараа материалын данс 4,544.5 мянган төгрөг болж 712.3 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст бичиг хэргийн материалын худалдан авалтаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 82,830.5 мянган төгрөг болж 5,817.6 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн тоног төхөөрөмж, шилжүүлэн авсан автомашин бүртгэснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 87,582.2 мянган төгрөг болж 6,737.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Баян-Өндөр сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 61,057.4 мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар, нийт зардал өмнөх оноос 21,219.2 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баян-Өндөр сумын ИТХ нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 236,331.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 236,331.4 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 11,652.6 мянган төгрөгөөр бууруулан 224,678.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 1 удаа тодотгосон бөгөөд төсвийг өөрчлөөгүй, зардлын зүйл хооронд шилжүүлж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 224,678.8 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс авч, урсгал үйл ажиллагаанд 221,644.0 мянган төгрөгийг зарцуулж, 3,034.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 221,644.0 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 623.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 210.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 560.5 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 286.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 608.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 714.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орхон аймгийн ИТХ-аас дэмжлэг болох 12,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 11,000.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баян-Өндөр сумын ИТХ нь 2021 онд нийт 258,089.7 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 258,089.7 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 300.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 166,460.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 150.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	1	300.0	1	300.0			
Албан шаардлага	2	166,460.0	2	166,460.0			
Зөвлөмж	2	150.0	2	150.0			
Нийт дүн	5	166,910.0	5	166,910.0			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баян-Өндөр сумын ИТХ-ын орон тоо Засгийн газраас тогтоосон хязгаарт нийцсэн эсэх, бичиг хэрэг, шатахууны зардлын төсөв их байдаг зэрэг нь дараагийн аудитаар анхаарал татахаар асуудал болж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 92,214.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 75,342.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 476.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 9,260.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 7,135.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн тэмдэглэл тайлбарыг ирүүлээгүй, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл эхний үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан, цалингийн зардал зөрүүтэй, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, татварын тайланд цалингийн зардлыг зөрүүтэй тайлагнасан, авлага тайлагнаагүй зэрэг алдааг нягталж, холбогдох дансанд залруулж тайлагнуулав.

4.2 Төлбөрийн акт

Тайлант онд 476.2 мянган төгрөгийн шатахууныг мөрдөж буй нормоос илүү олгож, хянаагүй тул төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Тайлант оны батлагдсан төсвөөс 2,517.9 мянган төгрөгийн тавилга, 152.0 мянган төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авч, Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй, 6,591.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөөгүй, хэмнэлт үүсгээгүйд 2 албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Кассаар бэлэн мөнгө авч зарцуулсан боловч нэмэлт санхүүжилтийн гүйлгээний баримтын хавсралтаар тайлагнаж, кассын тайлан гаргаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллаагүй, аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Бэлэн мөнгө авч зарцуулахдаа холбогдох хууль, журамд нийцүүлэн анхан шатны баримтыг хөтөлж, кассын тайлан гаргаж, баталгаажуулах.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант оны санхүүгийн тайлангийн тэмдэглэл тайлбарыг ирүүлээгүй, зөрүүтэй санхүүгийн тайлан ирүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”; 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”; 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллаагүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлж, хариуцлагыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Өндөр сумын ИТХ	8	92,214.9	3	75,342.8	1	476.2	2	9,260.9	2	7,135.0